



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/04


Улаанбаатар хот

Техникийн комисс томилох тухай

Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвд шинээр хүчилтөрөгчийн хийгээр хангах системийг угсарч суурилуулах ажлын “Петрохими” ХХК-тай байгуулсан 01/2017-УГ дугаартай гэрээг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Петрохими ХХК-тай байгуулсан 01/2017-УГ дугаартай гэрээний дагуу хийгдсэн ажлыг хүлээж авах комиссыг хавсралтаар баталсугай.
2. Хийж гүйцэтгэсэн хүчилтөрөгчийн хийгээр хангах ханын системийн чанарт хяналт тавьж, шалгаж авахыг комиссын гишүүдэд үүрэг болгосугай.
3. Хүчилтөрөгчийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч /З.Уранчимэг/-д, Тоног төхөөрөмжийн инженер /Т.Ариунсэлэнгэ/-д, барилгыг капиталжуулж бүртгэж авахыг Эд хөрөнгө хариуцсан нягтлан бодогч /Б.Үүрцайх/ нарт тус тус даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Д.Сүнжидмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ПҮРЭВЧУЛУУН

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
А/04 тоот тушаалын хавсралт



ТЕХНИКИЙН КОМИССЫН ГИШҮҮД

Комиссын дарга:

Н.Наташа /Аж ахуй эрхэлсэн орлогч дарга/

Комиссын нарийн бичгийн дарга:

З.Уранчимэг /Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч/

Гишүүд:

Д.Сүнжидмаа /Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга/

Б.Үүрцайх /Эд хөрөнгө хариуцсан нягтлан бодогч/

Т.Ариунсэлэнгэ /Тоног, төхөөрөмжийн инженер/